



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар

A/73

Амардалай

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, залуучуудын хөгжлийг дэмжих, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийг хавсралтаар баталсугай.

2.Залуучуудын боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжүүлэх талаар олон талт үйл ажиллагааны төлөвлөгөөг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Х.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

488010-315